



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 12 сарын 23 өдөр

Дугаар А/800

Булган сум

Журам шинэчлэн батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, Засгийн газрын 2021 оны 5 дугаар “Журам шинэчлэн батлах тухай” тогтоол, 2022 оны 8 дугаар “Журам шинэчлэн батлах, журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Аймгийн хошой аварга малчин өрх, Аймгийн аварга малчин өрх шалгаруулах журам”-ыг 1 дүгээр, “Аймгийн аварга саальчин шалгаруулах журам”-ыг 2 дугаар, “Аймгийн аварга фермер шалгаруулах журам”-ыг 3 дугаар, “Аймгийн аварга тариаланч хамт олон, Аймгийн аварга тариаланч шалгаруулах журам”-ыг 4 дүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2. Дээрх шагналд шаардагдах хөрөнгийг жил бүр аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын тамгын газрын дарга (Д.Эрдэнэбилэг)-д зөвшөөрсүгэй.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2019 оны А/589 дүгээр “Журам шинэчлэн батлах тухай”, аймгийн Засаг даргын 2021 оны А/30 дугаар “Журам шинэчлэн батлах тухай”, 2022 оны А/435 дугаар “Журам шинэчлэн батлах тухай” захирамжийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВ-ОЧИР

Аймгийн Засаг даргын 2025 оны
12 дугаар сарын 23-ны ний өдрийн
А/800 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралт



АЙМГИЙН ХОШОЙ АВАРГА МАЛЧИН ӨРХ, АЙМГИЙН АВАРГА МАЛЧИН ӨРХ ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Мал аж ахуйн үйлдвэрлэлийн үр ашиг, бүтээмжийг нэмэгдүүлэх, мал маллагааны уламжлалт аргыг боловсронгуй болгох, малын үүлдэрлэг байдал чанарыг сайжруулан, ашиг шимийг нэмэгдүүлэх, малаа мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд бүрэн хамруулахын зэрэгцээ нийгэмд оруулж байгаа хувь нэмрийг үнэлж, урамшуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад энэ журмын зорилго оршино.

1.2. Энэ журамд заасан шалгуур үзүүлэлтийг хангасан малчдын ажлын үзүүлэлтийг үндэслэн аймгийн хошой аварга малчин өрх, аймгийн аварга малчин өрхөөр тус тус шалгаруулна.

1.3. Аймгийн хошой аварга малчин өрх, аймгийн аварга малчин өрхөөр шалгаруулах шийдвэрийг Хүнс, хөдөө аж ахуйн газрын саналыг харгалзан Аймгийн Засаг даргын удирдлагын багийн хурлаар хэлэлцэж, Засаг даргын захирамжаар баталгаажна.

Хоёр. Шагналд тодорхойлоход тавигдах шалгуур үзүүлэлт

2.1. Аймгийн хошой аварга малчин өрх, аймгийн аварга малчин өрхөд тодорхойлох малчин өрх дараах шалгуур үзүүлэлтийг хангасан байна. Үүнд:

2.1.1. Мал сүргээ жилийн дөрвөн улиралд уламжлалт аргаар өөрөө малладаг, мал маллагааны туршлагаа залуу малчдад зааж сургаж шавь малчинтай болсон, түр болон байнгын ажлын байрыг бий болгож, орон нутагт ядуурлыг бууруулахад бодит хувь нэмэр оруулсан байх;

2.1.2. Өөрийн эзэмшлийн өвөлжөө, хаваржааны хашаатай, мал аж ахуйн үйлдвэрлэлээс олсон орлогоос доройтсон бэлчээрийг сайжруулах, худаг гаргах, булаг, шандын эхийг хамгаалахад зарцуулсан байх;

2.1.3. Бэлчээрийн даацад малын тоог тохируулан сумын бэлчээрийн менежментийн төлөвлөгөөний дагуу бэлчээрийг сэлгэн өнжөөх, отор, нүүдэл хийж зохистой ашигладаг, өвөл, хаврын улирлын бэлчээр ашиглах гэрээ байгуулан, бэлчээрийн хортон мэрэгчтэй тэмцэх бэлчээр хамгааллын ажилд идэвхтэй оролцдог байх;

2.1.4. Жил бүрийн мал өвөлжилт, хаваржилтад шаардлагатай өвс, тэжээлийг хонин толгойд шилжүүлснээр нэг малд ойт хээрийн бүсэд 50 кг, тал хээрийн бүсэд 40 кг байхаар тооцож бэлтгэж нөөцөлсөн байх;

2.1.5. Тухайн бүс нутгийн байгаль, цаг уурын онцлогт тохирсон төрөл, үүлдэр, омгийн малыг өсгөн үржүүлдэг, малын чанарыг сайжруулж, сүргийн зохистой бүтцийг бүрдүүлсэн байх;

2.1.6. Жил бүр үржлийн малдаа үзлэг ангилалтыг технологит хугацаанд хийлгэсэн байх;

2.1.7. Үржлийн малыг ялган тэмдэглэж малын бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгүүлсэн, үржлийн малын удам гарваль, ашиг шимийн чиглэл тодорхой байх;

2.1.8. Стандарт хэмжил зүйн газраас батлагдсан баталгаажсан үүлдэр омгийн малын стандартын шаардлага хангасан бог малын хээлтүүлэгчийг үржилд ашигладаг байх;

2.1.9. Хээлтэгчийн сүрэгт эзлэх хувийн жин бог малд 55, бод малд 40 болон түүнээс дээш хувьд хүрсэн, бодод шилжүүлснээр 100-аас доошгүй толгой малтай байх;

2.1.10. Сүргийн зохистой бүтцийг бүрдүүлэн сүрэгт эзлэх таваарын малын 40-өөс доошгүй хувийг жил бүр эдийн засгийн эргэлтэд оруулсан байх;

2.1.11. Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд малаа тогтмол, бүрэн хамруулж, малын эрүүл мэндийн дэвтэр хөтөлдөг, сүүлийн 3 жилд мал сүрэгт нь малын гоц халдварт болон халдварт өвчин гараагүй, малын зүй бус хорогдол 0.5 хувиас хэтрэхгүй байх;

2.1.12. Малын тоо толгойн албан татварыг тухайн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоосон хэмжээгээр бүрэн төлсөн байх;

2.1.13. Нийгмийн болон эрүүл мэндийн даатгалд гэр бүлийн гишүүд даатгуулж, малын индексжүүлсэн даатгалд малаа даатгуулсан байх;

2.1.14. Малчны хөдөлмөрийг хөнгөвчилсөн шинэ технологи, тоног төхөөрөмжийг мал аж ахуйн үйлдвэрлэлд нэвтрүүлсэн байх;

2.1.15. Хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй хүнсний хуванцар савнаас татгалзсан байх;

2.2. Малчны малын тоо, зах зээлд нийлүүлсэн бүтээгдэхүүний дүнд сүүлийн 1 жилд бусдаас худалдаж болон бэлгэнд авсан мал, бүтээгдэхүүнийг оруулж тооцохгүй;

Гурав. Аймгийн хошой аварга малчин өрх, аймгийн аварга малчин өрх шалгаруулах

3.1. Сумын Засаг даргын Тамгын газар нь сумын аварга малчнаар шалгарснаас хойш 3-аас доошгүй жил амжилтаа бататгасан, энэ журмын 2.1-д заасан шалгуур үзүүлэлтийг хангаж байгаа тус бүр 2 хүртэл малчин өрхийг аймгийн аварга малчин өрхөөр шалгаруулахаар тодорхойлно. Тодорхойлсон малчин өрх нь энэ журмын шалгуур үзүүлэлтийг хангаж байгааг нотлох баримт бичгийг хүснэгт 4-т заасны дагуу бүрдүүлэн багийн Иргэдийн Нийтийн Хурлын шийдвэр, сумын Засаг даргын тодорхойлолтын хамт жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны дотор аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газарт хүргүүлнэ.

3.2. Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар нь сумдаас аймгийн аварга малчин өрхөд тодорхойлж ирүүлсэн тодорхойлолт материалыг хянан үзээд жил бүрийн 01 дүгээр сарын 20-ны дотор аймгийн Засаг даргын удирдлагын багийн хурлаар хэлэлцүүлж, хамгийн өндөр үзүүлэлттэй 35 хүртэлх малчин өрхийг шалгаруулна.

3.3. Аймгийн хошой аварга малчнаар тодорхойлж байгаа малчны ажлын үзүүлэлтийг сүүлийн 5 жилээр гаргана.

3.4. Аймгийн аварга малчин болсноос хойш 3-аас доошгүй жил амжилтаа бататгасан, энэ журмын 2.1-д заасан шалгуур үзүүлэлтийг хангаж байгаа малчин өрхийг аймгийн хошой аварга малчин өрхөөр тодорхойлно.

3.5. "Аймгийн аварга малчин өрх"-өөр жил бүр 32 хүртэлх, "Аймгийн хошой аварга малчин өрх"-өөр 3 хүртэлх тооны малчин өрхийг шалгаруулна.

3.6. Тэмээ, үхэр голлон өсгөж байгаа малчин өрхийг "Аймгийн аварга малчин өрх"-өөр шалгаруулна.

3.7. Аймгийн хошой аварга малчин өрх, аймгийн аварга малчин өрхийг тодорхойлохдоо дараах бичиг баримтыг бүрдүүлсэн байна.

3.7.1. Малчин өрхийн (эхнэр, нөхөр) товч анкет /Хүснэгт 1/

3.7.2. Малчин өрхийн ажлын үзүүлэлт /Хүснэгт 2-3/

3.7.3. Холбогдох тодорхойлолт, баримт бичиг /Хүснэгт 4/

3.8. Хүнс, хөдөө аж ахуйн газар нь сумаас аймгийн хошой аварга малчин өрх, аймгийн аварга малчин өрхөд тодорхойлж ирүүлсэн малчин өрхийн холбогдох бичиг баримтыг малчин өрх тус бүрээр хянаж дүгнэлт гарган журмын шаардлагыг хамгийн сайн хангасан малчин өрхийг аймгийн хошой аварга малчин өрх, аймгийн аварга малчин өрхөөр шалгаруулахаар саналыг аймгийн Засаг даргын удирдлагын багийн хурлаар оруулж шийдвэрлүүлнэ.

3.9. Энэ журам батлагдахаас өмнө аймгийн сайн малчин цолоор шагнагдсан малчныг "Аймгийн аварга малчин өрх" цолтой адилтган үзнэ.

Дөрөв. Шагнал олгох

4.1. "Аймгийн аварга малчин өрх"-өөр шагнагдсан малчин өрхийг 1,100,000 (нэг сая нэг зуун мянга) төгрөгөөр шагнана. Аймгийн аварга малчин өрхөд олгох цолны үнэмлэх, энгэрийн тэмдэг, дурсгалын эд зүйлсийг худалдан авах хөрөнгийг мөнгөн шагналаас нь санхүүжүүлнэ.

4.2. Аймгийн хошой аварга малчин өрх цолоор шагнагдсан малчин өрхийг 1,300,000 (нэг сая гурван зуун мянга) төгрөгөөр шагнана. Аймгийн хошой аварга малчин өрхөд олгох цолны үнэмлэх, энгэрийн тэмдэг, дурсгалын эд зүйлсийг худалдан авах хөрөнгийг мөнгөн шагналаас нь санхүүжүүлнэ.

4.3. Шагналыг билгийн тооллын хаврын тэргүүн сарын шинийн нэгний өдрөөс өмнө гардуулна.

4.4. Аймгийн хошой аварга малчин өрх, аймгийн аварга малчин өрхийн шагнал гардуулах ажлыг нэгдсэн байдлаар зохион байгуулж аварга малчин өрхийг алдаршуулна.



АЙМГИЙН АВАРГА СААЛЬЧИН ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Мал аж ахуйн үйлдвэрлэлд тогтвортой, үр бүтээлтэй ажиллаж, төллөсөн малаа саальд бүрэн хамруулж, өрхийн үйлдвэрлэлээр хамгийн их сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэж зах зээлд нийлүүлж, хүн амын хүнсний хангамжийг нэмэгдүүлэхэд саальчны оруулсан хувь нэмрийг үнэлж урамшуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад энэ журмын зорилго оршино.

1.2. Энэ журмын шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангасан саальчны ажлын үзүүлэлтийг үндэслэн аймгийн аварга саальчнаар шалгаруулна.

1.3. "Аймгийн аварга саальчин"-аар шалгаруулж, шагнал олгох шийдвэрийг Хүнс, хөдөө аж ахуйн газрын саналыг харгалзан аймгийн Засаг даргын удирдлагын багийн хурлаар хэлэлцэж, Засаг даргын захирамжаар баталгаажна.

Хоёр. Шагналд тодорхойлоход тавигдах шаардлага

2.1. Аймгийн аварга саальчнаар тодорхойлох саальчин дараах шаардлагыг хангасан байна:

2.1.1. Оны эхэнд байсан малын тоо нь бодод шилжүүлснээр 100-аас доошгүй байх бөгөөд 100 хээлтэгчээс бойжуулсан төлийн тоо аймгийн дунджаас илүү байх;

2.1.2. Сүрэгт эзлэх хээлтэгч мал бог малд 55, бод малд 40-өөс доошгүй хувь байх;

2.1.3. Төллөсөн бүх хээлтэгчийг саальд бүрэн хамруулж, нийт саасан сүүний хэмжээ жил дараалан өссөн байх;

2.1.4. Нэг хээлтэгчээс сааж байгаа сүү нь тухайн орон нутагт үржүүлж байгаа үүлдэр, омгийн малын ашиг шимийн дундаж үзүүлэлтээс дээгүүр байх, сүү, цагаан идээгээ зах зээлд борлуулсан байх;

2.1.5. Мэргэжлийн байгууллагаас ангилалт хийж, удам гарваль, ашиг шимийг нь тогтоосон, стандартын шаардлага хангасан малыг үржилд ашигладаг, малаа малын бүртгэл мэдээллийн нэгдсэн бүртгүүлсэн байх;

2.1.6. Ой хээрийн бүсэд хонин толгойд шилжүүлснээр нэг малд 50 кг, тал хээрийн бүсэд 40 кг-аас доошгүй өвстэй тэнцэхүйц өвс, гар тэжээл, дарш, хүчит тэжээлийг жил бүр бэлтгэж нөөцөлсөн байх;

2.1.7. Мал саах, саалиа боловсруулах арга ажиллагаагаа зааж сурган шавь саальчинтай болсон байх;

2.1.8. Мал сүргээ эрүүл байлгах, урьдчилан сэргийлэх арга хэмжээнд бүрэн хамруулсан байх;

2.1.9. Бэлчээрийн даацад малынхаа тоог тохируулж, сумын бэлчээрийн менежментийн төлөвлөгөөний дагуу хуваарьтай ашиглаж, бэлчээр хамгаалах арга хэмжээ авдаг байх;

2.1.10. Мал үржүүлэг технологийн нэгжээр үржлийн малдаа жил бүр үзлэг ангилалт хийлгэсэн байх;

2.1.11. Таваарын малын 30-аас доошгүй хувийг жил бүр эдийн засгийн эргэлтэд оруулсан байх;

2.1.12. Өөрийн ашиглаж байгаа бэлчээрт хортон мэрэгч, шавжтай энгийн механик болон микробиологийн аргаар тэмцсэн байх;

2.1.13. Өөрийн эзэмшлийн өвөлжөө, хаваржаа, малын хашаа, саравч, худагтай байх.

2.2. Аймгийн аварга саальчинд фермерийн аж ахуйн саальчныг тодорхойлохгүй.

Гурав. Аварга саальчнаар тодорхойлох, шалгаруулах

3.1. Сумын аварга саальчин болсноос хойш хоёроос доошгүй жил амжилттай ажилласан, энэ журамд заасан шаардлага, ажлын үзүүлэлтийг хангасан 1 саальчныг тухайн сумын Засаг даргын Тамгын газраас аймгийн аварга саальчнаар шалгаруулахаар тодорхойлж, багийн Иргэдийн нийтийн хурлаар хэлэлцүүлсэн шийдвэр, сумын Засаг даргын тодорхойлолтын хамт жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны дотор аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газарт хүргүүлнэ.

3.2. Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар нь сумаас ирүүлсэн аймгийн аваргад тодорхойлогдсон саальчны холбогдох бичиг баримтыг хянан үзээд жил бүрийн 1 дүгээр сарын 20-ны дотор аймгийн Засаг даргын удирдлагын багийн хурлаар хэлэлцүүлж, хамгийн өндөр үзүүлэлттэй 3 хүртэл саальчны тодорхойлолтыг шалгаруулна.

3.3. Аймгийн аварга саальчнаар тодорхойлохдоо дараах бичиг баримтыг бүрдүүлсэн байна.

3.3.1. Саальчны товч анкет Хавсралт-1

3.3.2. Ажлын үзүүлэлт Хавсралт-2

3.3.3. Холбогдох байгууллагын тодорхойлолт болон тодорхойлолтын баталгаа Хавсралт-3

Дөрөв. Шагнал олгох

4.1. Аймгийн аварга саальчин тус бүрийг 500,000 (Таван зуун мянга) төгрөгөөр шагнана. Аймгийн аварга саальчинд олгох цолны үнэмлэх, энгэрийн тэмдэг, өргөмжлөл, дурсгалын эд зүйлсийг худалдан авах хөрөнгийг мөнгөн шагналаас нь санхүүжүүлнэ.

4.2. Шагналыг билгийн тооллын хаврын тэргүүн сарын шинийн нэгний өдрөөс өмнө гардуулна.

4.3. Аймгийн аварга саальчны шагнал гардуулах ажлыг нэгдсэн байдлаар зохион байгуулж алдаршуулна.

--o00o--

Аймгийн Засаг даргын 2025 оны
12 дугаар сарын 23 нынй өдрийн
А/800 дугаар захирамжийн 3 дугаар хавсралт

“АЙМГИЙН АВАРГА ФЕРМЕР” ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Өндөр ашиг шимтэй мал, амьтан өсгөн үржүүлж, зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, хүн амын хүнсний хангамжийг нэмэгдүүлж байгаа эрчимжсэн аж ахуй эрхлэгчдийг урамшуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.

1.2.Энэ журамд заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангасан эрчимжсэн аж ахуй эрхлэгч иргэн, аж ахуйн нэгжийг сүүлийн 3 жилийн ажлын үзүүлэлтийг үндэслэн “Аймгийн аварга фермер”-ээр шалгаруулна.

1.3.“Аймгийн аварга фермер” –ээр шалгаруулж шагнал олгох шийдвэрийг Хүнс, хөдөө аж ахуйн газрын саналыг харгалзан аймгийн Засаг даргын удирдлагын багийн хурлаар хэлэлцэж, Засаг даргын захирамжаар баталгаажна.

Хоёр. Шагналд тодорхойлох үндэслэл

2.1.“Аймгийн аварга фермер”-ээр шагнуулахаар тодорхойлох эрчимжсэн аж ахуй эрхлэгч нь дараах шаардлагыг хангасан байна.

2.1.1.Байгаль орчинд сөрөг нөлөөгүй үйл ажиллагаа эрхэлж, орчны ариун цэвэр, эрүүл ахуй, халдваргүйжүүлэлтийг шийдвэрлэсэн, экологийн цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэх нөхцөлийг бүрдүүлсэн байх;

2.1.2.Мал, амьтныг эрсдэлээс хамгаалах даатгалд хамруулж, холбогдох хууль тогтоомжийн дагуу татвар, хураамж, нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл тогтмол төлсөн байх;

2.1.3.Малаа гоц халдварт болон халдварт, паразитах өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд бүрэн хамруулж, эрүүл сүрэгтэй болохыг мэргэжлийн байгууллагаар баталгаажуулсан байх;

2.1.4.Мал бүрийг эзэмгжүүлж, бүртгэлжүүлсэн, үржилд ашиглаж байгаа малын анги, ашиг шимийн гарц, чанарыг мэргэжлийн байгууллагаар баталгаажуулсан байх;

2.1.5.Хэрэглэгчийн захиалгаар үржлийн мал, амьтан бойжуулж, нийлүүлсэн байх;

2.1.6.Эрчимжсэн аж ахуй эрхэлж байгаа туршлагаа залуу малчдад эзэмшүүлэх талаар санаачилга гарган ажиллаж, 3-аас доошгүй ажлын байр шинээр бий болгосон байх.

Гурав. Эрчимжсэн аж ахуй эрхлэгч фермерүүдэд тавих шалгуур үзүүлэлт

3.1.Аймгийн аварга фермерээр шагнуулахаар тодорхойлох эрчимжсэн аж ахуй эрхлэгч нь энэ журмын 2.1.1-2.1.6-д заасан шаардлагаас гадна дараах шалгуур үзүүлэлтийг хангасан байна:

3.1.1.Өндөр ашиг шимтэй нэг үүлдрийн мал, амьтныг сонгон үржүүлдэг, үйлдвэрлэж байгаа бүтээгдэхүүний хэмжээ жил дараалан өссөн байх;

3.1.2.Тухайн үүлдрийн мал, амьтны арчилгаа маллагааны технологи, эрүүл ахуйн шаардлагыг бүрэн хангасан зориулалтын байр, тоног төхөөрөмжтэй байх;

3.1.3.Эрүүл ахуйн шаардлага хангасан бүтээгдэхүүнийг үйлдвэрлэдэг байх;

3.1.4.Мал, амьтны чанар, ашиг шимийг нэмэгдүүлэх, бүтээгдэхүүний чанарыг сайжруулах чиглэлээр шинэ техник, тоног төхөөрөмж, дэвшилтэт арга технологи нэвтрүүлэхэд хөрөнгө оруулалт хийж, тодорхой үр дүнд хүрсэн байх;

3.1.5.Саалийн болон махны чиглэлийн аж ахуй эрхлэгч иргэн 20-иос доошгүй га, аж ахуйн нэгж 100-гаас доошгүй га газрыг хашиж хамгаалан ногоон тэжээл тариалдаг байх;

3.1.6.Үржилд ашиглаж байгаа мал, амьтан бүр удам гэрваль, ашиг шимийн бүртгэл хөтөлдөг байх;

3.1.7.Сүүний чиглэлийн үхрийн аж ахуй эрхэлж байгаа иргэн 30, аж ахуйн нэгж 60 толгойгоос доошгүй стандартын шаардлага хангасан үнээтэй байх, зохиомол хээлтүүлэг хийдэг, нэг үнээнээс жилд дунджаар 3700-гаас доошгүй литр сүү саасан, сүүний үйлдвэрлэл нь жил дараалан өссөн байх;

3.1.8.Махны үхрийн аж ахуй эрхэлж байгаа иргэн 50, аж ахуйн нэгж 100-аас доошгүй үнээтэй, оны эхний нэг үхрээс 150-200 кг-аас доошгүй мах үйлдвэрлэж, үйлдвэрлэсэн махны хэмжээ жил дараалан өссөн байх;

3.1.9.Махны чиглэлийн хонь үржүүлж байгаа иргэн 200, аж ахуйн нэгж 300-гаас доошгүй эм хоньтой, оны эхний нэг хониноос 20 кг-аас доошгүй мах үйлдвэрлэж, үйлдвэрлэсэн махны хэмжээ жил дараалан өссөн байх;

3.1.10.Гахайн аж ахуй эрхэлж байгаа иргэн 10, аж ахуйн нэгж 60-аас доошгүй үндсэн мэгжтэй, мэгж бүрээс жилд 20-иос доошгүй торой бойжуулж, мах үйлдвэрлэл нь жил дараалан өссөн байх;

3.1.11.Өндөглөгч шувуу үржүүлж байгаа өрх, аж ахуйн нэгж нь оны эхэнд 5000-аас доошгүй өндөглөгчтэй, нэг өндөглөгчөөс жилд 280-аас доошгүй өндөг үйлдвэрлэсэн байх;

3.1.12.Зөгийн аж ахуй эрхэлж байгаа иргэн 30 бүл, аж ахуй нэгж нь 300 бүл зөгий үржүүлж, 1 бүлээс жилд 20 кг -аас доошгүй бал хураан авсан байх;

Дөрөв. Шагналд тодорхойлох, шалгаруулах

4.1.Сумын Засаг даргын Тамгын газар сумын аварга фермер болсноос хойш гурваас доошгүй жил амжилтаа тогтвортой хадгалан ажиллаж, энэ журмын шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангасан фермерыг сумаас "Аймгийн аварга фермер"-ээр тодорхойлж, багийн Иргэдийн нийтийн хурлаар хэлэлцүүлсэн шийдвэр, сумын Засаг даргын тодорхойлолт, хүсэлтийн хамт жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны дотор аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газарт хүргүүлнэ.

4.2.Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар нь сумаас ирүүлсэн тодорхойлолт, холбогдох бичиг баримтыг хянаж шаардлага хангасан хамгийн өндөр үзүүлэлттэй 3 фермерийн тодорхойлолтыг жил бүрийн 1 дүгээр сарын 05-ны дотор аймгийн Засаг даргын удирдлагын багийн хурлаар хэлэлцүүлж шалгаруулна.

4.3."Аймгийн аварга фермер"-ээр шалгаруулахаар тодорхойлохдоо дараах бичиг баримт бүрдүүлсэн байна:

4.3.1.Фермерийн анкет Хавсралт-1

4.3.2.Ажлын үзүүлэлтүүд Хавсралт-2

4.3.3.Холбогдох байгууллагын тодорхойлолт болон тодорхойлолтын баталгаа
Хавсралт-3

4.4.Мал, гахай, шувууны тоо, бүтээгдэхүүний дүнд бусдаас худалдан авсан болон өр төлбөр, бэлгэнд авсан мал, гахай, шувуу, зөгийн бүтээгдэхүүнийг тооцохгүй.

4.5.Эрчимжсэн аж ахуй эрхлэгчийг “Аймгийн аварга фермер”-ээр зөвхөн нэг удаа шалгаруулна.

4.6.Энэ журам батлагдахаас өмнө нь “Аймгийн тэргүүний фермер” болж байсан фермерыг “Аймгийн аварга фермер”-тэй адилтган үзэх бөгөөд дахин шагнахгүй.

Тав. Шагнал олгох

5.1.“Аймгийн аварга фермер” ээр шагнагдаж байгаа эрчимжсэн аж ахуй эрхлэгчийг 800,000 (Найман зуун мянга) төгрөгөөр шагнана. Аймгийн аварга фермерт цолны үнэмлэх, энгэрийн тэмдэг, өргөмжлөл, дурсгалын эд зүйлсийг худалдан авах хөрөнгийг мөнгөн шагналаас нь санхүүжүүлнэ.

5.2.Шагналыг билгийн тооллын хаврын тэргүүн сарын шинийн нэгний өдрөөс өмнө гардуулах ажлыг нэгдсэн байдлаар зохион байгуулж алдаршуулна.

--o00o--

**“АЙМГИЙН АВАРГА ФЕРМЕР”-Т ТОДОРХОЙЛОХ
ИРГЭНИЙ ТОВЧ АНКЕТ**

Цээж зураг
(6x4)
өнгөт *

.....онсар өдөр

1	Аймаг, сум, багийн нэр	
2	Ургийн овог	
3	Эцэг (эх)-ийн нэр	
4	Нэр	
5	Төрсөн он, нас, хүйс	
6	Боловсрол	
7	Ам бүлийн гишүүдийн тоо	
8	Улсад ажилласан жил	
9	Үүнээс: малчнаар ажилласан жил	
10	Сумын аварга фермерээр шалгарсан үнэмлэхийн дугаар, огноо	

**АЙМГИЙН АВАРГА ФЕРМЕРТ ТОДОРХОЙЛОХ
АЖ АХУЙН НЭГЖИЙН ТОВЧ АНКЕТ**

.....онсар өдөр

1	Аймаг, сум, багийн нэр	
2	Аж ахуйн нэгжийн нэр	
3	Байгуулагдсан он сар өдөр	
4	Үйл ажиллагааны чиглэл	
5	Боловсон хүчний мэдээлэл	
6	Үйл ажиллагаа явуулж байгаа хугацаа	
7	Сумын аварга фермерээр шалгарсан он, үнэмлэхийн дугаар	
8	Шагнагдсан төрийн одон, медаль огноо	

**АЙМГИЙН АВАРГА ФЕРМЕРЭЭР
ТОДОРХОЙЛОХ.....СУМЫН.....БАГИЙН СУУНИЙ ҮХРИЙН
АЖ АХУЙ ЭРХЛЭГЧ -НЫ АЖЛЫН ҮЗҮҮЛЭЛТ**

.....онсар өдөр

д/д	Үзүүлэлт	Онууд		
	 он он он
1	Үржүүлж байгаа үхрийн үүлдэр			
2	Оны эхэнд байгаа нийт үхэр (тоо)			
	Үүнээс: а/ үнээ (тоо)			
	б/ бойжуулсан тугал (тоо)			
3	Үйлдвэрлэсэн нийт сүү (тонн)			
4	Саалийн 305 хоногт нэг үнээнээс саасан сүү (литр)			
5	Үржилд худалдсан үхрийн тоо			
	Үүнээс: а/ өсвөр хээлтүүлэгч			
	б/ өсвөр хээлтэгч			
6	Бүртгэлд авч баталгаажуулсан цөм сүргийн малын тоо			
7	Зохиомлоор хээлтүүлсэн үнээний тоо			
8	Жилд шаардагдах тэжээлийн нийт хэмжээ (тонн)			
	Үүнээс: өөрийн хүчээр бэлтгэсэн: а/хүчит тэжээл (тонн)			
	б/ дарш (тонн)			
	в/ өвс (тонн)			
9	Тэжээлийн ургамал тариалсан нийт талбайн хэмжээ (га)			
	а/ хураан авсан нийт тэжээлийн ургамал (цн)			
	б/ нэг га-гаас авсан ургац (цн)			
10	Нэг үхэрт зарцуулсан тэжээлийн хэмжээ (тэжээлийн нэгж)			
11	Үхрийн байрны багтаамж м ²			
12	Ашиглаж байгаа худгийн хүчин чадал литр/сек			
13	Оны эцэст тоологдсон нийт үхэр			
	Үүнээс: үнээ (тоо)			
14	Оруулсан хөрөнгө оруулалт (мян.төг)			
15	Жилийн борлуулалтын нийт орлого (мян.төг)			
16	Жилд олсон цэвэр ашиг (мян.төг)			
17	Малчны дундаж цалин (мян.төг)			
18	Эрүүл мэнд, нийгмийн даатгалд төлсөн шимтгэл (мян.төг)			

----- СУМЫН ЗАСАГ ДАРГА ----- (.....)

ХӨДӨӨ АЖ АХУЙН ТАСГИЙН ДАРГА ----- (.....)

**АЙМГИЙН АВАРГА ФЕРМЕРЭЭР ТОДОРХОЙЛОХСУМЫН
БАГИЙН МАХНЫ ҮХЭР (ХОНЬ)-ИЙН АЖ АХУЙ ЭРХЛЭГЧ
 -НЫ АЖЛЫН ҮЗҮҮЛЭЛТ**

.....онсар өдөр

д/д	* Үзүүлэлт	Онууд		
	он онон
Нэг. Эрчимжсэн аж ахуй эрхлэгчийн ажлын үзүүлэлт				
1	Үржүүлж байгаа үхэр (хонь)-ийн үүлдэр			
2	Оны эхэнд байгаа нийт үхэр, эсхүл хонины тоо			
	Үүнээс: а/ хээлтэгч (тоо)			
	б/ хээлтүүлэгч (тоо)			
	в/ бойжуулсан төл (тоо)			
3	Үйлдвэрлэсэн нийт мах (тонн)			
4	Оны эхний нэг малаас үйлдвэрлэсэн мах (кг), (нядалгын жингээр)			
5	Зах зээлд борлуулсан нэг үхэр, эсхүл хонины дундаж амьдын жин (кг)			
6	Үржилд худалдсан нийт үхэр, эсхүл хонины тоо			
	Үүнээс: а/ өсвөр хээлтүүлэгч			
	б/ өсвөр хээлтэгч			
7	Бүртгэлд авч баталгаажуулсан цөм сүргийн тоо			
8	Зохиомлоор хээлтүүлсэн малын тоо			
9	Жилд шаардагдах тэжээлийн нийт хэмжээ (тонн)			
	Үүнээс: а/өөрийн хүчээр бэлтгэсэн тэжээл (тонн)			
	б/ худалдаж авсан тэжээл (тонн)			
10	Тэжээлийн ургамал тариалсан нийт талбайн хэмжээ (га)			
11	Хураан авсан нийт тэжээлийн ургамал (цн)			
12	Нэг га-гаас авсан ургац			
13	Нэг малд зарцуулсан тэжээлийн хэмжээ (тэжээлийн нэгж)			
14	Хашааны багтаамж (м ²)			
15	Худгийн хүчин чадал (литр/сек)			
16	Оны эцэст тоологдсон нийт мал			
	Үүнээс: а/ хээлтэгч (тоо)			
	б/ хээлтүүлэгч (тоо)			
17	Хөрөнгө оруулалт (мян.төг)			
18	Жилийн борлуулалтын нийт орлого (мян.төг)			
19	Жилд олсон цэвэр ашиг (мян.төг)			
20	Нэг ажилтны дундаж цалин (мян.төг)			
21	Эрүүл мэнд, нийгмийн даатгалд төлсөн шимтгэл (мян.төг)			

----- СУМЫН ЗАСАГ ДАРГА ----- (.....)

ХӨДӨӨ АЖ АХУЙН ТАСГИЙН ДАРГА ----- (.....)

**АЙМГИЙН АВАРГА ФЕРМЕРЭЭР ТОДОРХОЙЛОХСУМЫН
.....БАГИЙН ГАХАЙ, ШУВУУ, ЗӨГИЙН АЖ АХУЙ ЭРХЛЭГЧ -
НЫ АЖЛЫН ҮЗҮҮЛЭЛТ**

.....онсар өдөр

д/д	*	Үзүүлэлт	Онууд		
		ононон
Нэг. Гахайчны ажлын үзүүлэлт					
1		Үржүүлж байгаа гахайн үүлдэр			
2		Оны эхэнд байгаа нийт гахайны тоо			
		а/ үндсэн мэгжийн тоо			
		б/ үржилд ашиглах бодонгийн тоо			
		в/ бойжуулсан нийт торойн тоо			
		г/ нэг мэгжнээс бойжуулсан торой			
3		Үйлдвэрлэсэн нийт гахайн мах (тонн)			
4		Маханд борлуулсан нэг гахайн дундаж амьдын жин (кг)			
5		Үржилд худалдсан шалгалтын мэгжний тоо			
6		Оны эцэст тоологдсон нийт гахай			
		Үүнээс: үндсэн мэгжийн тоо			
7		Цөм сүргийн гахайны тоо			
8		Жилд шаардагдах тэжээлийн нийт хэмжээ (тонн)			
		а/ өөрийн хүчээр үйлдвэрлэсэн (тонн)			
		б/ худалдан авсан тэжээл (тонн)			
9		Жилийн борлуулалтын нийт орлого (мян.төг)			
10		Жилд олсон цэвэр ашиг (мян.төг)			
11		Оруулсан хөрөнгө оруулалт (мян.төг)			
12		Эрүүл мэнд, нийгмийн даатгалд төлсөн шимтгэл (мян.төг)			

Хоёр. Шувуучны ажлын үзүүлэлт

д/д		Үзүүлэлт	онууд		
			.. он	.. он	.. он
1		Үржүүлж байгаа шувууны үүлдэр			
2		Оны эхэнд байгаа нийт шувууны тоо			
		Үүнээс: өндөглөгч шувууны тоо			
3		Нийт үйлдвэрлэсэн өндөг (мян.ширхэг)			
		Үүнээс: борлуулсан өндөг (мян. ширхэг)			
4		Бойжуулсан дэгдээхэй			
5		Үржилд худалдсан шувуу			
6		Үйлдвэрлэсэн мах (кг)			
7		Эх сүргийн шувууны тоо			
8		Жилд шаардагдах тэжээлийн нийт хэмжээ (тн)			
		Үүнээс: өөрийн хүчээр бэлтгэж, үйлдвэрлэсэн (тн)			
		- худалдан авсан тэжээл (тн)			
9		Оны эцэст байгаа нийт шувуу			
		Үүнээс: өндөглөгч шувууны тоо			
10		Оруулсан хөрөнгө оруулалт (мян.төг)			
11		Жилийн борлуулалтын нийт орлого (мян.төг)			
12		Жилд олсон цэвэр ашиг (мян.төг)			

13	Нэг ажилчны дундаж цалин (мян.төг)			
14	Эрүүл мэнд, нийгмийн даатгалд төлсөн шимтгэл (мян.төг)			
Гурав. Зөгийчний ажлын үзүүлэлт				
д/д	Үзүүлэлт	Онууд		
		... он	... он	... он
1	Үржүүлж байгаа зөгийн үүлдэр			
2	Зөгийг өвөлжүүлэх зоорины багтаамж/мк/			
3	Оны эхний зөгийн бүлийн тоо			
4	Хураангавсан балны хэмжээ /кг /			
5	Үүнээс худалдан борлуулсан орлого /мян.төг/			
6	Бойжуулсан бүлийн тоо			
	Үүнээс: Худалдан борлуулсан тоо /мян.төг/			
7	Бусад бүтээгдэхүүнээс орсон орлого /мян.төг /			
8	Жилийн борлуулсан нийт орлого /мян.төг /			
9	Жилд олсон цэвэр ашиг / мян.төг/			
10	Нэг ажилчны дундаж цалин /мян.төг /			
11	Эрүүл мэнд, нийгмийн даатгалд төлсөн шимтгэл/ мян.төг/			

Тайлбар: Үзүүлэлтийг сумын Засаг даргын Тамгын газар шалгаж баталгаажуулна.

----- СУМЫН ЗАСАГ ДАРГА ----- (.....)

ХӨДӨӨ АЖ АХУЙН ТАСГИЙН ДАРГА ----- (.....)

**АЙМГИЙН АВАРГА ФЕРМЕРЭЭР ТОДОРХОЙЛОХ
..... СУМЫН БАГИЙН-ЫН АЖЛЫН ҮЗҮҮЛЭЛТ,
ТОДОРХОЙЛОЛТЫН БАРИМТ БИЧИГ**

1. Фермерийн ажил байдлын тодорхойлолт;
2. Фермерийн малын А дансны хуулга сүүлийн 3 жилээр;
3. Иргэний үнэмлэхийн хуулбар;
4. Сумын аварга фермерийн үнэмлэхийн хуулбар;
5. Малын эрүүл мэндийн дэвтрийн хуулбар;
6. Малын тоо толгойн албан татвар төлсөн тухай цахим лавлагаа;
7. Өрхийн гэр бүлийн гишүүдийн нийгмийн даатгал төлсөн цахим лавлагаа;
8. Өрхийн гэр бүлийн гишүүдийн эрүүл мэндийн даатгал төлсөн цахим лавлагаа;
9. Малын индексжүүлсэн даатгалын гэрээний хуулбар, мөнгө төлсөн баримт;
10. Малчин үржлийн малдаа үзлэг ангилалт хийлгэсэн тухай сумын Хөдөө аж ахуйн тасгийн тодорхойлолт;
11. Малчин малаа мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд бүрэн хамруулсан тухай сумын Мал эмнэлгийн тасгийн тодорхойлолт;
12. Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэмдэглэл;
13. Сумын Засаг даргын албан хүсэлт;
14. Сумын Засаг даргын удирдлагын багийн хурлын шийдвэр,
15. Мал тоо толгойн албан татвар тогтоосон тухай, сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тогтоолын хуулбар;

Тайлбар:

1. Холбогдох баримтыг хавсаргаагүй бол баталгаа хүчингүйд тооцогдоно.
2. Дээрх хавсралтад заасан үзүүлэлт бүрээр тус тусад нь баталгаа гаргана.

----- СУМЫН ЗАСАГ ДАРГА ----- (.....)



АЙМГИЙН АВАРГА ТАРИАЛАНЧ ХАМТ ОЛОН, АЙМГИЙН АВАРГА ТАРИАЛАНЧ ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Газар тариалангийн үйлдвэрлэлд хөрс хамгаалах дэвшилтэт техник, технологи нэвтрүүлж эрчимжүүлэх, нэгжээс хураан авах ургац, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлэх, чанарыг сайжруулах замаар аж ахуйн нэгж, иргэний, нийгэмд оруулж байгаа хувь нэмрийг урамшуулахад энэхүү журмын зорилго оршино.

2. Энэхүү журмын шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангасан 3 хүртэл аж ахуйн нэгжийг сүүлийн 3 жилийн ажлын үзүүлэлтээр нь шалгаруулж “Аймгийн аварга тариаланч хамт олон”-оор, мөн сүүлийн 3 жилийн ажлын үзүүлэлтээр нь ногоочин, механикжуулагч тус бүр 2 хүртэл, мэргэжилтэн, жимсчин тус бүр нэгийг шалгаруулж “Аймгийн аварга тариаланч”-аар жил бүр шалгаруулна.

3. “Аймгийн аварга тариаланч хамт олон”, “Аймгийн аварга тариаланч”-аар шалгаруулан, шагнах асуудлыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтэс болон Хүнс, хөдөө аж ахуйн газрын саналыг үндэслэн аймгийн Засаг даргын удирдлагын хурлаар шийдвэрлэнэ.

Хоёр. Шагналд тодорхойлох үндэслэл

“Аймгийн аварга тариаланч хамт олон”, “Аймгийн аварга тариаланч”-аар шалгаруулах аж ахуйн нэгж, байгууллага, иргэд нь дараах шаардлага, шалгуур үзүүлэлтүүдийг хангасан байна.

“Аймгийн аварга тариаланч хамт олон” шалгаруулах шаардлага, шалгуур:

1.1. Хамт олон нь жил бүр үр тариа, малын тэжээлийн ургамал усалгаатай нөхцөлд 100 га, усалгаагүй нөхцөлд 300 га, төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ 10-аас доошгүй га-д тариалж, нэгжээс хураан авсан ургац нь сүүлийн 3 жилд аймгийн дунджаас 20-оос доошгүй хувиар илүү байх;

1.2. Хөрсний үржил шимийг хамгаалах, чийгийн хуримтлалыг нэмэгдүүлэхэд чиглэсэн дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэн, чанар сайтай уринш бэлтгэн, бэлтгэсэн уриншийн 80-аас доошгүй хувийг химийн болон хавах технологиор боловсруулж, тэжээлийн ургамлыг сэлгээнд оруулах, тариалангийн талбайд хамгаалалтын зурвас байгуулах ажлыг зохион байгуулсан байх,

1.3. Үр тариа, төмсний үйлдвэрлэл эрхлэгчид нь эргэлтийн талбайгаа 100 хувь ашиглаж, дараа оны тариалалтад зориулан хүрэлцэхүйц хэмжээний чанар сайтай үр нөөцөлсөн байх;

1.4. ХАА-н техникийн бэлэн байдал, хангамжийг сайжруулан, технологит ажлууд (тариалалт, уринш боловсруулалт, ургац хураалт)-ыг графикт хугацаанд нь гүйцэтгэсэн байх;

1.5.Тариалангийн тухай хууль болон тариалангийн талбайг мал, тэжээвэр амьтдаас хамгаалах талаар журмын хэрэгжилтийг хангаж, малын эрсдэл бүхий талбайг хашиж хамгаалсан байх;

1.6.Аж ахуйн нэгж байгууллага нь өөрийн үйл ажиллагаагаа өргөжүүлэхэд болон сум, орон нутгийн нийгмийн салбарт хөрөнгө оруулалт хийж, шинээр ажлын байр бий болгох, ажилтнуудынхаа мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд тодорхой хувь нэмэр оруулсан байх;

1.7.Татвар, хураамж болон газрын төлбөрийг хугацаанд нь төлсөн байх, хугацаа хэтэрсэн өр зээлгүй байх;

1.8.Үйлдвэрлэлийн үйл ажиллагааг хэвийн явуулж, осол зөрчил гаргаагүй байх;

1.9.Тариалангийн тухай хуулийн 25.1-д заасан хөрс хамгаалах, сайжруулах үйл ажиллагаа болон ургамал хамгааллын цогц арга хэмжээг хэрэгжүүлсэн байх;

1.10.хөдөө аж ахуйн зохистой дадал нэвтрүүлсэн байх, аж ахуйн нэгж нь хөдөө аж ахуйн инженер, агрономичтой байх;

1.11.Талбайн түүх хөтөлсөн байх, ургамлын гарал үүсэл, бүртгэл хяналтын систем (www.plant.mofa.gov.mn)-д бүртгүүлсэн байх;

1.12.Статистик мэдээллийг цаг тухайд нь сум, дүүргийн хөдөө аж ахуйн тасаг, холбогдох бусад байгууллагуудад хүргүүлж мэдээллийн нэгдсэн системд оруулсан байх;

1.13.Тариалангийн талбайд ойн зурвас байгуулсан байх;

“Аймгийн аварга мэргэжилтэн” шалгаруулах шаардлага, шалгуур:

2.1.Ажиллаж байгаа сум, байгууллага, аж ахуйн нэгжид үйлдвэрлэлийн технологийн картыг мөрдүүлж, талбайн түүх хөтлөн таримлын сэлгээг нэвтрүүлэн үр ашгийг дээшлүүлсэн байх;

2.2.Газар тариалангийн үйлдвэрлэлийн дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлж, уринш боловсруулалт, үрийн үйлдвэрлэл нөөцлөлт, газар ашиглалтыг сайжруулах талаар идэвх санаачилгатай ажиллан үйлдвэрлэлд шинэ дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэхэд тодорхой хувь нэмэр оруулсан байх;

2.3.Хөрсний үржил шимийг хамгаалах нөхөн сэргээх талаар санал санаачилга гарган ажилласан байх;

2.4.Газар тариалангийн үйлдвэрлэлд ажиллах залуу халаа, мэргэжлийн ажилтан бэлтгэхэд тодорхой үүрэг гүйцэтгэсэн байх;

“Аймгийн аварга ногоочин, жимсчин” шалгаруулах шаардлага, шалгуур:

3.1.Төмс, хүнсний ногоог 1.0 га, жимс жимсгэнэ 0.5 га-гаас доошгүй талбайд тариалалт хийж, нэгжээс хураан авсан ургац нь сүүлийн 3 жилийн үзүүлэлтээр аймгийн дунджаас 20-оос доошгүй хувиар илүү байх;

3.2.Сүүлийн 3 жилийн үзүүлэлтээр жил бүр нэгжээс төмс 140 цн, байцаа 220 цн, үндэс үрт ногоо 140 цн, сонгинолог ургамал 110 цн, нэг м.квт талбайгаас өргөст хэмх 16 кг, улаан лооль 10 кг – аас доошгүйг хураан авсан байх;

3.3.Төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнийг стандартын шаардлагын дагуу хадгалах зоорь агуулахтай байхын зэрэгцээ, хэрэгцээт төмсний үрээ 100 хувь өөртөө нөөцөлж хадгалсан байх;

3.4.Хөрсний үржил шимийг нэмэгдүүлж, таримлын зохистой сэлгээг мөрдөж, бордоог өргөн ашиглаж ургац нэмэгдүүлсэн байх;

3.5.Хөрсний агрохимийн шинжилгээг хугацаанд нь өгсөн байх; (шинжилгээний дүнгийн хуудсыг үндэслэнэ)

3.6.Бүтээгдэхүүний борлуулалттай холбогдуулан талбайн түүх хөтөлж, хувийн тамгатай болсон байх, гарал үүслийн гэрчилгээ авч хэвшсэн байх;

“Аймгийн аварга механикжуулагч” шалгаруулах шаардлага, шалгуур:

4.1.Сүүлийн 3 жил дараалан үр тарианы комбайнаар шууд хураалтад шилжүүлснээр 300 га, трактораар 500 жишмэл га-гаас доошгүй ажил гүйцэтгэсэн байх;

4.2.Техникийн хүчин чадлыг бүрэн ашиглаж, хөрс боловсруулалт, тариалалт, уринш, ургац хураалтын ажлыг агро техникийн шаардлагын дагуу чанартай гүйцэтгэн, шатахуун, сэлбэг хэмнэж ажилласан байх;

4.3.Үйлдвэрлэлд нэвтэрч буй техникийг бүрэн эзэмших дадлага сургалтад хамрагдсан, тодорхой мэдлэг эзэмшсэн байх;

4.4.Хамт олондоо нэр хүнд сайтай, хүлээн зөвшөөрөгдөхүйц байх;

Гурав. Тодорхойлолт бүрдүүлэх, шалгаруулах

“Аймгийн аварга тариаланч хамт олон”, “Аймгийн аварга тариаланч”-ийг шалгаруулахдаа гурваас доошгүй жил тогтвортой амжилт гаргасан, аж ахуйн нэгж, иргэдийг гурван жилийн дараа дахин шалгаруулж болно.

Сумын Засаг даргын тамгын газраас “Аймгийн аварга тариаланч хамт олон”, “Аймгийн аварга тариаланч”-аар шалгаруулах аж ахуйн нэгж, иргэний тодорхойлолт, холбогдох материалыг бүрдүүлж, нийгмийн хариуцлагын хүрээнд хийсэн ажлыг баримтжуулан, жил бүрийн 01 дүгээр сарын 15-ны дотор аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газарт ирүүлнэ.

Тодорхойлолтод ажлын үзүүлэлтүүдийг хэрхэн биелүүлснийг тусгах бөгөөд сумын Засаг даргын Тамгын газраар баталгаажуулсан байна.

“Аймгийн аварга тариаланч хамт олон”, “Аймгийн аварга тариаланч”-аар шалгаруулахаар тодорхойлохдоо дор дурдсан материалыг бүрдүүлнэ. Үүнд:

1.Аймгийн аваргад тодорхойлогдож байгаа аж ахуйн нэгж болон тариаланч, мэргэжилтэн, механикжуулагч, ногоочин, жимсчний товч анкет, сумын Засаг даргын тодорхойлолт;

2.Холбогдох байгууллагуудаас гаргасан баталгаа, тодорхойлолт (Татварын хэлтэс, нийгмийн даатгалын хэлтэс, хөрсний шинжилгээний дүн, талбайн түүх гэх мэт);

3.Сүүлийн 3 жилийн ажлын үзүүлэлтийг хавсралт хүснэгтийн дагуу гаргана.

Дөрөв. Шагнал олгох

1.“Аймгийн аварга тариаланч хамт олон”-д өргөмжлөл, 1,000,000 (нэг сая) төгрөг, “Аймгийн аварга тариаланч”-д тус бүр, өргөмжлөл 500,000 (таван зуун мянга) төгрөг олгоно. Өргөмжлөлийн үнийг шагналын мөнгөнөөс нь тооцно.

2.Шагналыг билгийн тооллын хаврын тэргүүн сарын шинийн нэгний өмнө гардуулна.

“Аймгийн аварга тариаланч хамт олон”, “Аймгийн аварга тариаланч”-ийг шалгаруулах үзүүлэлт:

д/д	Шалгуур үзүүлэлт	Шалгуур тооцох он /сүүлийн 3 жил/			Тайлбар
		... он	... он	... он	
1	Тариалангийн эргэлтийн талбай /га/				
	Үүнээс: Тарьсан /га/				
	Уриншилсан /га/				
2	Таримлын төрөл				
3	Хураан авсан ургац /тн/				
	Үүнээс: Нөөцөлсөн үр /тн/				
	Зах зээлд борлуулсан ургац /тн/				
4	Нэгжийн ургац, цн/га				
	Үүнээс: Усалгаатай талбайгаас, цн/га				
	Усалгаагүй талбайгаас, цн/га				
5	Нийт борлуулалт /сая.төг/				
	Үүнээс: Татварт /сая.төг/				
	Даатгалд /сая.төг/				
	Ашиг /сая.төг/				
6	Ажлын байрны тоо				
7	Нийгмийн даатгалын шимтгэлд төлсөн орлого				
8	Трактораар гүйцэтгэсэн ажил /жишмэл, га/				
9	Комбайнаар хураасан талбай /шууд, га/				

Тайлбар: Энэ хүснэгтэд зөвхөн сүүлийн 3 жилийн ажлын үзүүлэлтийг бичнэ. Шагнагдах үндэслэлийн талаар тодорхойлолтдоо дэлгэрэнгүй бичиж, холбогдох байгууллагын тодорхойлолтыг шалгуур үзүүлэлтүүдийн дагуу гаргаж ирсэн байна. Дээрх хүснэгтийн 8, 9-т заасан ажлын хэмжээ нь зөвхөн трактор комбайнч /механикжуулагч/-д хамаарна. Шалгаруулсан материалыг шаардлагатай гэж үзвэл газар дээр нь шалгаж, дүгнэлт гаргана.

Үзүүлэлтийг сумын Засаг даргын Тамгын газар шалгаж баталгаажуулна.

----- СУМЫН ЗАСАГ ДАРГА ----- (.....)